



МОНГОЛ УРСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
 ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР**

13381 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
 Засгийн газрын IX байр,
 Утас: (976-51) 26 23 50, И-мэйл: info@pcsp.gov.mn,
 Вэбсайт: www.pcsp.gov.mn

2020.04.08 № А-4/534

-ны №

Зөвшөөрөл олгох тухай


Танай ирүүлсэн үндсэн хөрөнгө данс, бүртгэлээс хасах тухай 2020 оны 01/323 дугаартай албан бичигтэй танилцлаа.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь заалт, 31 дүгээр зүйл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны "Журам шинэчлэн батлах тухай" 271 дүгээр тогтоолын 2.1 дэх заалтыг үндэслэн Харилцаа холбооны зохицуулах хорооны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, сэргээн засварлах боломжгүй болох нь тогтоогдсон 22 нэрийн 55,623,604.00 (тавин таван сая зургаан зуун хорин гурван мянга зургаан зуун дөрвөн) төгрөгийн балансын үнэтэй хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрч байна.

Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэлд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэж, шийдвэрийн биелэлтийг 2020 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэхийг мэдэгдье.

Хавсралт 1 хуудастай.

ДАРГА



З.МЭНДСАЙХАН



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 07 сарын 06 өдөр

Дугаар 403

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн ашиглалтын
хугацаа сунгах, үнийг шинэчлэн тогтоох
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олгож авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7.1 дэх заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Харилцаа холбооны зохицуулах хорооны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, хэргэлдээрээ анхны өртгөө нөхсөн боловч ашиглаж болох нийт 4 нэрийн 420,497,893.71 (дөрвөн зуун хорин сая дөрвөн зуун ерэн долоон мянга найман зуун ерэн гурван төгрөг далан нэгэн мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу ашиглах хугацааг сунгаж, үнийг нийт 100,892,148.95 (нэг зуун сая найман зуун ерэн хоёр мянга нэг зуун дөчин найман төгрөг ерэн таван мөнгө) төгрөгөөр шинэчлэн тогтоохыг зөвшөөрсүгэй.
2. Харилцаа холбооны зохицуулах хорооны дарга Г.Чинзоригт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:
 - 2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасны дагуу хөрөнгийн ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоох ажлыг хялбар болгох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;
 - 2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг хөгжүүлэх систем"-д бүртгэх;
 - 2.3. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.
3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

З.МЭНДСАЙХАН

Д.НАРАНГЭРЭЛ



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2020 оны 11 сарын 24 өдөр

Дугаар 581

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны "Зөвшөөрөл олгох тухай" 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Харилцаа холбооны зохицуулах хорооны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 3 жилийн нийт 67,466,120.57 (жаран долоон сая дөрвөн зуун жаран зургаан мянга нэг зуун хорин төгрөг тавин долоон мөнгө) төгрөгийн балансын үнэ, 11,772,689.10 (арван нэгэн сая долоон зуун далан хоёр мянга зургаан зуун наян есөн төгрөг арван мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий автомашиныг хавсралтад заасны дагуу балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Харилцаа холбооны зохицуулах хорооны дарга Г.Чинзориг, "МИАТ" хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Д.Баттөр, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Захиргаа удирдлагын албаны дарга Н.Ганболд нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг хүлээлцэх, балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ





МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГЭРЛЭГ
ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

ТӨСӨТ Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
Засгийн газрын өргөн тал, Төрийн өмчийн бодлого,
зохицуулалтын газар
Утас/факс: (011) 2422 50 | И-мэйл: info@stat.gov.mn |
Хуудас: www.stat.gov.mn

АХУ.ОМ.ОБ. 1.4534
Танай _____ -ийн № _____

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ДАРГА Г.ЧИНЗОРИГ ТАНАА

Зөвшөөрөл олгох тухай


Танай ирүүлсэн үндсэн хөрөнгө данс, бүртгэлээс хасах тухай 2020 оны 01/323 дугаартай албан бичигтэй танилцлаа.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь заалт, 31 дүгээр зүйл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны "Журам шинэчлэн батлах тухай" 271 дүгээр тогтоолын 2.1 дэх заалтыг үндэслэн Харилцаа холбооны зохицуулах хорооны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, сэргээн засварлах боломжгүй болох нь тогтоогдсон 22 нэрийн 55,623,604.00 (тавин таван сая зургаан зуун хорин гурван мянга зургаан зуун дөрвөн) төгрөгийн балансын үнэтэй хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрч байна.

Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэлд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэж, шийдвэрийн биелэлтийг 2020 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэхийг мэдэгдье.

Хавсралт 1 хуудастай.

ДАРГА



З.МЭНДСАЙХАН